Ес зүйн хорооны 2025 оны 12 дугээр сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БОЛОН ХАРЬЯА ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын Мал эмнэлгийн ерөнхий газар болон 21 аймаг, нийслэл, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ гэсэн 25 дэд хороо байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 86 хувьтай байна. Салбарын хэмжээнд Төрийн албаны зөвлөл болон аймгууд дахь төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан ёс зүйн холбогдолтой 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1256 албан хаагч хамрагдсан. Ёс зүйн дэд хороо тус бүр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын талаар дэд хороо бүрээс албан хаагчдад мэдээлэл сургалт хийж ёс зүйн сахилга, хариуцлагыг дэмжиж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээллээр ханган ажиллав. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд нийт 25 дэд хороо үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан байна. Баталсан төлөвлөгөөнүүдийг хөтөлбөрийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлэхэд зарим төлөвлөгөө нь хэмжигдэхүйц үзүүлэлтгүй, хэрэгжилтийн хугацаа тодорхой бус, үр дүнг үнэлэгдэхүйц бус зэрэг нийтлэг дутагдал илэрсэн тул цаашид сайжруулах талаар дэд хороодод зөвлөмж өглөө. Ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг хууль, журамд заасны дагуу гаргах талаарх ойлголт зарим дэд хороодын түвшинд хангалттай бүрдээгүй байна. Мэдүүлэг гаргасан тохиолдол харьцангуй цөөн бөгөөд ихэнхдээ удирдах албан тушаалтнуудын хүрээнд төвлөрсөн, бүх шатны албан хаагчдыг хамарсан тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг бүртгэх маягтыг ашиглан бүртгэлийг тогтмол, журмын дагуу хөтөлсөн бол зарим тохиолдолд маягт дутуу бөглөгдсөн, мэдээлэл нэгтгэн дүгнэхэд хүндрэл учруулж байна.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан байдал 93%, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал-78%, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал-40% биелэлттэй байна. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан байдлыг дүгнэн үзэхэд ихэнх нь байгууллагын хувьд ёс зүйн дэд хорооноос дүгнэлт гаргаагүй тохиолдол зонхилж байгаа байгаа нь шийдвэрийн биелэлт өндөр (93%) харагдахад нөлөөлж байна. Харин МЭЕГ-ын хувьд ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн дагуу холбогдох шийдвэр гаргаагүй нь

ёс зүйн зөрчилд хариуцлага тооцох тогтолцооны хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна.

Мөн ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал 40 хувийн биелэлттэй байгаа нь дэд хорооны үйл ажиллагааг тогтвортой, идэвхтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг хангалтгүй байгааг харуулж, цаашид анхаарал хандуулах шаардлагатай асуудал болж байна.

Томилох эрх бүхий албан тушаалтнууд нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч ёс зүйн манлайллын түвшин жигд бус байна.

Ёс зүйн бодлого, төлөвлөлт дэх манлайллын хувьд томилох эрх бүхий албан тушаалтнуудын удирдлага дор дэд хороод үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлалсан нь ёс зүйн асуудлыг анхаарч байгааг илтгэж байна. Гэвч төлөвлөгөө нь үндэсний хөтөлбөрийн зорилго, шалгуур үзүүлэлттэй бүрэн нийцээгүй, бодит үр дүнг хэмжих боломж сул байгаа нь удирдлагын түвшинд чиглүүлэг, шаардлага тодорхой өгөөгүй байгааг харуулж байна.

Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулахад томилох эрх бүхий албан тушаалтнуудын оролцоо ихэвчлэн даалгавар өгөх түвшинд хязгаарлагдаж, өөрсдөө үлгэрлэн оролцох, ёс зүйн үнэт зүйлийг байгууллагын соёл болгон төлөвшүүлэх манлайлал сул илэрч байна. Үүний улмаас соён гэгээрүүлэх ажлын нөлөөлөл тогтвортой, үр дүнтэй байж чадаагүй байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Мал эмнэлгийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь 2025 оны тайлант хугацаанд Мал эмнэлгийн ерөнхий газрын албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан гэх 10 өргөдлийн хүрээнд нийт 9 удаа хурлыг зохион байгуулан тодруулан холбогдох мэдээллийг авч өргөдлийг шийдвэрлэн 2 гомдлын хүрээнд ёс зүйн зөрчилтэй талаарх дүгнэлт гарган томилох эрх бүхий албан тушаалтан болон холбогдогчдод хүргүүллээ.

Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулан ёс зүйн зөрчил болон холбогдох материал, шийдвэрлэлтийг цаг тухай бүрд нь Монгол Улсын ёс зүйн хорооны “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем” болох hrm.csc.gov.mn цахим системд бүртгэж ажилласан байна.

Харъяа салбар 24 ёс зүйн дэд хорооны тайлангаас дүгнэхэд жилийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байна.

Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал 97% хэрэгжсэн дүнтэй бөгөөд нийт 10 гомдол, мэдээллийг шийдвэрлэн ёс зүйн зөрчилгүй 6 асуудлыг нотлох баримтын хүрээнд тодруулан, ёс зүйн зөрчилтэй 4 асуудалд холбогдох дүгнэлтийг гарган ажилласан байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Мал эмнэлгийн ерөнхий газар болон салбар харьяа газрууд хамт олны саналыг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн дагуу дэд хороодыг байгуулан, тогтмол үйл ажиллагаа явуулж хэвшсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийт 25 дэд хороо үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан байна. Ёс зүйн дэд хороодын зүгээс соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг дэд хороо бүр зохион байгуулж, ёс зүйн мэдлэг,	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал хангалтгүй байна. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулахад шаардагдах зардлын асуудал шийдэгдээгүй. Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг, зөрчлийн бүртгэлийн тогтолцоо жигд бус.

ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, уулзалт, зөвлөгөөн, мэдээлэл түгээх ажлуудыг хийж гүйцэтгэсэнээр ёс зүйн төлөвшилт, хамт олны харилцаа хандлагын хувьд эерэг нөлөө үзүүлэхэд бодитой нөлөөлөл болсон байна.	

Санал:

- Үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлттэй нийцүүлэх
- Төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын талаар дэд хороодод сургалт зохион байгуулах
- Соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, удирдах албан тушаалтны оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх
- Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлэх

Шалгах хэсэг:

- ☐ "Ес зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

_____ _____ А.НАРАНТУЯА

/Албан тушаал/ Гарын үсэг Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

_____ _____ Б.ЧУЛУУНЧИМЭГ

/Албан тушаал/ Гарын үсэг Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

_____ _____ Х.МЭНДСҮРЭН

/Албан тушаал/ Гарын үсэг Гарын үсгийн тайлал/

2026 оны 01 сарын 22-өдөр

"МЭЕГ" БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо [1]	Мал эмнэлгийн салбарын дэд хороо /25/																								Оноо [1]	Хувийн жин[2]
						УБ	АР	БӨ	БУ	БХ	ГА	ГС	ДА	ДО	ДГА	ДУ	ЗА	ОР	ӨВ	ӨМ	СҮ	СЭ	ТӨ	УВ	ХО	ХӨ	ХЭ	УМЭАЦТЛ	МЭЭСБУЛ	НМЭГ	МЭЕГ		
1	2	3		4	5	6		7	8	9		10	11	12		13	14	15				16	17	18		19	20	21		22	23	24		25	26
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (YXX)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлсан эсэх[4]		1	1	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	0.5	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	0.5	1.0	1.0	1.0	1.0	1.0	-	1.0	1.0	1	0.96	96%
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	1.0	1.0	1.0	-	1.0	-	-	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	-	-	-	-	-	0.4	1.0	0.5	0.676	68%
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0	-	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5		0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	0.44	88%
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0	-	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.3	-	0.5	0.452	90%
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	1	1.0	0.5	0.5	-	0.5	0.5	-	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	0.5	-	0.5	-	0.5	1.0	0	0.42	84%
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0.5	1	1.0	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	0.5	0.5	0.5	0.5	-	0.5	-	0.5	0.5	0.5	0.5	1.0	0	0.48	96%
Хэсгийн оноо				**4**	**4**	**4**	**4**	**4**	**2.5**	**4**	**3**	**1.5**	**4**	**3.5**	**4**	**4**	**3**	**4**	**4**	**4**	**3.5**	**3.5**	**3**	**3**	**2.5**	**2.5**	**3**	**1.5**	**3.2**	**4**	**2.5**	3.43	86%
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэгийн (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*аврсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо*)		1	1	1.0	1.0	1.0	0.7	0.5	1.0	-	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	0	0.928	93%
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан [11]		1	1	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	-	1.0	1.0	1.0	1.0	0.5	0.5	1.0	-	-	1.0	1.0	0.5	-	1.0	1.0	-	1.0	1.0	1	0.78	78%
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0	-	1.0	-	-	1.0	-	-	-	-	1.0	-	-	1.0	-	1.0	1.0	-	-	1.0	-	1.0	1.0	-	-	-	1	0.4	40%
Хэсгийн оноо				**3**	**2**	**2**	**3**	**2**	**1.7**	**2.5**	**2**	**0**	**2**	**2**	**3**	**2**	**1.5**	**2.5**	**2**	**2**	**2**	**2**	**2**	**2.5**	**1**	**3**	**3**	**1**	**2**	**2**	**2**	2.1	70%
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0		1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	-	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1	0.96	96%
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (*Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын нийлбэр тоонд*)		1	1	1.0	1.0	1.0	0.7	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	-	1.0	1.0	1.0	1.0	0.5	1.0	1.0	1.0	1.0	1	0.968	97%
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	1.0	1.0	1.0	-	1.0	1.0	-	1.0	-	1.0	1.0	-	1.0	1.0	1.0	1.0	-	-	1.0	1.0	1.0	1.0	-	1.0	1.0	1	0.76	76%
Хэсгийн оноо				**3**	**3**	**3**	**3**	**3**	**1.7**	**3**	**3**	**2**	**3**	**1**	**3**	**3**	**2**	**3**	**3**	**3**	**2**	**1**	**2**	**3**	**3.0**	**2.5**	**3**	**2**	**3**	**3**	**3**	2.7	90%
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9**	**9**	**10**	**9**	**5.9**	**9.5**	**8**	**3.5**	**9**	**6.5**	**10**	**9**	**6.5**	**9.5**	**9**	**9**	**7.5**	**6.5**	**7**	**8.5**	**6.5**	**8**	**9**	**4.5**	**8.2**	**9**	**7.5**	**8.2**	**82.2**

БАТЛАВ
ЕС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА С.БАТХҮЯГ
2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРОНХИЙ ГАЗРЫН ЕС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэх албан хаагч	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн байдал	Шаардлагатай зардал
1	МЭЕГ, харьяа байгууллагын албан хаагчдаас төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх	2-р улирал	Б.Чулуунчимэг	Хамруулсан албан хаагчийн тоо	500	Байхгүй
2	МЭЕГ, харьяа байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх	2-р улирал	Э.Мөнхбаяр	Хамруулсан албан хаагчийн тоо	500	Байхгүй
3	МЭЕГ-ын албан хаагчдаас ёс зүйн зөрчил, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх	3-р улирал	Н.Буянтогтох	Хамруулсан албан хаагчийн тоо	40	Байхгүй
4	МЭЕГ-ын харьяа байгууллагын албан хаагчдаас ёс зүйн зөрчил, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх	3-р улирал	Н.Буянтогтох	Хамруулсан албан хаагчийн тоо	500	Байхгүй
5	Судалгааны үр дүнг нэгтгэх, танилцуулах	4-р улирал	Ёс зүйн дэд хороо	Тайлангийн тоо	1	Байхгүй
6	Харьяа байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх	4-р улирал	Ёс зүйн дэд хороо	Зөвлөмжийн тоо	1	Байхгүй
7	Төлөвлөгөөний төслийг шинэчлэн боловсруулах, батлах, хэрэгжилт хангах	3-р улирал	Э.Мөнхбаяр	Шинэчлэгдсэн төлөвлөгөө	тийм	Байхгүй
8	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил түүнд оногдуулсан хариуцлагын бүртгэлийг цахим системд хөтлөх	Тогтмол	Э.Мөнхбаяр	Цаг хугацаанд нь бүртгэсэн байдал	Өргөдөл, гомдлыг хүлээн авсанаас шийдвэрлэх хүртэлх үйл явцыг цаг хугацаанд нь цахим системд бүрдүүлсэн байна	Байхгүй
9	Шинээр томилогдсон албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн талаарх гарын авлага материалыг танилцуулах	Тогтмол	Л.Нямхүү	Тараах материалын тоо	10	50,000
10	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний чиглэлээр сургалт зохион байгуулах	1-р улирал	Э.Мөнхбаяр	Сургалт зохион байгуулсан тухай тайлан	албан хаагчдын 80-аас дээш хувийг хамруулсан байна	Байхгүй
11		4-р улирал	Ёс зүйн дэд хороо		албан хаагчдын 80-аас дээш хувийг хамруулсан байна.	200,000
12	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлын МЭЕГ-ын нийт албан хаагчдын дунд зохион байгуулах	2-р улирал	Н.Буянтогтох	Хүрсэн ажилтны тоо, мэдээллийн чанар	40-өөс цөөнгүй албан хаагчид мэдээлэл хүргэсэн байна	50,000

13	Ес зүйн зөрчлийн тапаарх өгөгдөл, гомдлыг хүлээн авч хянаж шийдвэрлэх.	Тогтмол	Ес зүйн дэд хороо	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн гомдлын эзлэх хувь	100	Байхгүй
14	Ес зүйн зөрчлийн асуудлаар ирсэн өгөгдөл, гомдолд дүн шинжилгээ хийх.	Жил бүр	Ес зүйн дэд хороо	Тайлангийн тоо	2	Байхгүй
15	МЭЕГ-ын болон харьяа байгууллагуудын ес зүйн дэд хорооны гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, чадавхжуулах.	4-р улирал	Дарга	Хамруулсан харьяа байгууллагын Ес зүйн дэд хорооны эзлэх хувь	50-аас багагүй	Байхгүй
16	Ес зүйн дэд хорооны төлөвлөгөөний хэрэжилтийг МЭЕГ-ын мэдээллийн цагаар нийт албан хаагчдад танилцуулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд санал авах.	4-р улирал	Ес зүйн дэд хорооны гишүүд	Танилцуулгын тоо	1-ээс багагүй	Байхгүй
17	Үйлчлүүлэгчидтэй харилцаж ажилладаг албан хаагчдын ес зүй, түүний зөрчлийн асуудлаар санал, хүсэлтийн хайрцаг байрлуулж харилцагч аж ахуйн нэгжүүдээс санал хүсэлт авах.	3-р улирал	Н.Буянтогтох	Дүн шинжилгээний тайлангийн тоо	1	50,000
18	Ес зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагаатай холбоотой материалын бүрдлийг хангаж архивын нэж үүсгэх, архивт хүлээлгэн өгөх.	4-р улирал	Э.Мөнхбаяр	Архивын нэжийн тоо	1	Байхгүй

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан хаагч	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн байдал	Шаардлагатай зардал	Биелэлт /%/
1	МЭЕГ, харьяа байгууллагын албан хаагчдаас төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх.	2-р улирал	Б.Чулуунчимэг	Хамруулсан албан хаагчийн тоо	500	Байхгүй	100
2	МЭЕГ, харьяа байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх.	2-р улирал	Э.Мөнхбаяр	Хамруулсан албан хаагчийн тоо	500	Байхгүй	100
3	МЭЕГ-ын албан хаагчдаас ёс зүйн зөрчил, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх.	3-р улирал	Н.Буянтогтох	Хамруулсан албан хаагчийн тоо	40	Байхгүй	75
4	МЭЕГ-ын харьяа байгууллагын албан хаагчдаас ёс зүйн зөрчил, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлох асуумж судалгаа авах, үр дүнг нэгтгэх.	3-р улирал	Н.Буянтогтох	Хамруулсан албан хаагчийн тоо	500	Байхгүй	50
5	Судалгааны үр дүнг нэгтгэх, танилцуулах.	4-р улирал	Ёс зүйн дэд хороо	Тайлангийн тоо	1	Байхгүй	50
6	Харьяа байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх.	4-р улирал	Ёс зүйн дэд хороо	Зөвлөмжийн тоо	1	Байхгүй	100
7	Төлөвлөгөөний төслийг шинэчлэн боловсруулах, баталж, хэрэгжилт хангах.	3-р улирал	Э.Мөнхбаяр	Шинэчлэгдсэн төлөвлөгөө	тийм	Байхгүй	75
8	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил түүнд оногдуулсан хариуцлагын бүртгэлийг цахим системд хөтлөх.	Тогтмол	Э.Мөнхбаяр	Цаг хугацаанд нь бүртгэсэн байдал	Өргөдөл, гомдлыг хүлээн авсанаас шийдвэрлэх хүртэлх үйл явцыг цаг хугацаанд нь цахим системд байршуулсан	Байхгүй	100
9	Шинээр томилогдсон албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн талаарх гарын авлага материалыг танилцуулах.	Тогтмол	Л.Нямхүү	Тараах материалын тоо	10	50000	20
10	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний чиглэлээр сургалт зохион байгуулах.	1-р улирал	Э.Мөнхбаяр	Сургалт зохион байгуулсан тухай тайлан	албан хаагчдын 80-аас дээш хувийг хамруулсан байна.	Байхгүй	100
11		4-р улирал	Ёс зүйн дэд хороо		албан хаагчдын 80-аас дээш хувийг хамруулсан байна.	200000	80
12	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлын МЭЕГ-ын нийт албан хаагчдын дунд зохион байгуулах.	2-р улирал	Н.Буянтогтох	Хүрсэн ажилтны тоо, мэдээллийн чанар	40-өөс цөөнгүй албан хаагчид мэдээлэл хүргэсэн байна.	50000	20
13	Ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч хянаж шийдвэрлэх.	Тогтмол	Ёс зүйн дэд хороо	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн гомдлын	100	Байхгүй	100
14	Ёс зүйн зөрчлийн асуудлаар ирсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх.	Жил бүр	Ёс зүйн дэд хороо	Тайлангийн тоо	2	Байхгүй	100
15	МЭЕГ-ын болон харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хорооны гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах.	4-р улирал	Дарга	Хамруулсан харьяа байгууллагын Ёс зүйн	50-аас багагүй	Байхгүй	0
16	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг МЭЕГ-ын мэдээллийн цагаар нийт албан хаагчдад танилцуулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд санал авах.	4-р улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд	Танилцуулгын тоо	1-ээс багагүй	Байхгүй	0
17	Үйлчлүүлэгчидтэй харилцаж ажилладаг албан хаагчдын ёс зүй, түүний зөрчлийн асуудлаар санал, хүсэлтийн хайрцаг байрлуулж харилцагч аж ахуйн нэгжүүдээс санал хүсэлт авах.	3-р улирал	Н.Буянтогтох	Дүн шинжилгээний тайлангийн тоо	1	50,000	20
18	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагаатай холбоотой материалын бүрдлийг ханган архивын нэгж үүсгэх, архивт хүлээлгэн өгөх.	4-р улирал	Э.Мөнхбаяр	Архивын нэгжийн тоо	1	Байхгүй	100
	Хэрэгжилтийн дундаж хувь						66.1

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА — Б.ЧУЛУУНЧИМЭГ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ — Э.МӨНХБАЯР

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хот

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Мал эмнэлгийн ерөнхий газар нь Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын хүрээнд Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг, Мал, амьтны халдварт өвчний хяналт, хорио цээр, хязгаарлалтын асуудал хариуцсан мал эмнэлгийн улсын ахлах байцаагч Л.Нямхүү, Мал эмнэлгийн үйлчилгээний хяналт хариуцсан мал эмнэлгийн улсын ахлах байцаагч Б.Чулуунчимэг, Мал, амьтны эмийн үлдэгдлийн хяналт, эм, биобэлдмэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Мөнхбаяр, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Буянтогтох нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороог Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/217 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна.

Тус Ёс зүйн дэд хороо нь 2025 оны тайлант хугацаанд Мал эмнэлгийн ерөнхий газрын албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан гэх 10 өргөдлийн хүрээнд нийт 9 удаа хурлыг зохион байгуулан тодруулан холбогдох мэдээллийг авч өргөдлийг шийдвэрлэн ажиллаа. Үүнд:

1. Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Эрдэнэдалай, Захиргаа санхүүгийн албаны дарга Г.Мөнхсарнай, нягтлан бодогч Саранцацрал нартай холбоотой Авлигатай тэмцэх газрын 05/4459 тоот албан бичгээр ирүүлсэн гомдлын дагуу хянан үзэхэд өргөдөл гарггачийн нэр, хаяг тодорхойгүй тул Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл годмлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заасан шаардлагыг хангаагүй тул хянан шийдвэрлэх боломжгүй гэж шийдвэрлэв.

2. Улаанбаатар хотын иргэн А.Баасанхүүгээс ирүүлсэн Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал Ө.Гэрэлмаатай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдлийг хянан үзэж холбогдогч Ө.Гэрэлмаа нь ёс зүйн зөрчил гаргаагүй болохыг тогтоосон.

3. Говь-Алтай аймгийн иргэн О.Нямзул /96486969-утасны дугаар/ нь Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Р.Бүрэнбаясахтай холбоотой ёс зүйн зөрчил

гаргасан тухай өргөдлийн хянан үзэж холбогдогч Р.Бүрэнбаясах нь ёс зүйн зөрчил гаргаагүй болохыг тогтоосон.

4. Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын албан хаагч Э.Будсүрэн, Н.Мөнхнайрамдал нараас ирүүлсэн Дорнод аймгийн мал эмнэлгийн газрын дарга Ч.Аюушмаатай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдлийг хянан үзэхэд холбогдогч Ч.Аюушмаа нь ёс зүйн зөрчил гаргасан эсэх нь тогтоогдоогүй.

5. Булган аймгийн Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн Э.Сүглэгмаагаас ирүүлсэн Булган аймгийн мал эмнэлгийн газрын дарга Г.Одсүрэнтэй холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдлийг хянан үзэж холбогдогч Г.Одсүрэн нь ёс зүйн зөрчил гаргасан дүгнэлтийг гарган ажиллав.

6. Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга А.Алтангартаам /99569464-утасны дугаар/ -аас ирүүлсэн Говьсүмбэр аймгийн мал эмнэлгийн газрын дарга Ч.Отгонсүрэнтэй холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг хянан үзэж Ч.Отгонсүрэн нь ёс зүйн зөрчил гаргасан байна гэж дүгнэлт гаргав.

7. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Мал эмнэлгийн улсын байцаагч П.Аюушжав /94045352, 86086040-утасны дугаар/ -аас ирүүлсэн Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газрын Эрүүл мэндийн албаны дарга Б.Атланзултай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдлийг Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газрын Ёс зүйн дэд хороонд шилжүүлэн ажилласан.

8. Ховд аймгийн сумдын Мал эмнэлгийн тасгийн 24 нэр бүхий албан хаагч /төлөөлөгч Ш.Пүрэвхүү/ -аас ирүүлсэн Ховд аймгийн мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга Б.Мөнхбаатар, Б.Хасбат, Ю.Энх-Амгалан нартай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг хянан үзэж гомдол гаргагч нарын төлөөлөл Ш.Пүрэвхүүтэй Zoom хурал зохион байгуулан тухайн өргөдөл нь Мал эмнэлгийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны харьяалах асуудал биш болохыг тайлбарлан Харья Ховд аймгийн Мал эмнэлгийн газрын ёс зүйн дэд хороонд хандахыг зөвлөн тус өргөдлийг хааж шийдвэрлэсэн.

9. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын засаг дарга С.Гончигнямаас ирүүлсэн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Мал эмнэлгийн тасгийн Т.Чандмаа холбоотой ёс зүйн зөрчил гаргасан гэх өргөдлийн хянан шийдвэрлэсэн. Тус өргөдөл Цагаан-Уул сумын засаг дарга С.Гончигням нь холбогдогч Т.Чандмаатай холбоотой Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын Ёс зүйн дэд хороо нь ямар нэг арга хэмжээ аваагүй тухай ирүүлсэн. Үүний дагуу тодруулахад Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын Ёс зүйн дэд хороо нь Т.Чандмаатай холбоотой гомдлыг хянаж үзэн шийдвэрлэсэн байсан. Иймд Мал эмнэлгийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь тухай Хөвсгөл аймгийн Ёс зүйн дэд хорооны дүгнэлттэй санал нийлэхгүй тохиолдолд хянал үзэх эрх зүйн зохицуулалттай тул гомдлыг буцааж шийдвэрлэсэн.

10. Говьсүмбэр аймгийн иргэн Б.Сарнайгаас ирүүлсэн Говьсүмбэр аймгийн мал эмнэлгийн газрын дарга Ч.Отгонсүрэнтэй холбоотой ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг хянан үзэхэд нотлох баримт байхгүй тул холбогдогч Ч.Отгонсүрэн нь ёс зүйн зөрчил гаргаагүй гэж тус тус шийдвэрлэн ажиллаа.

Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд бүртгэгдсэн Ёс зүйн зөрчил болон холбогдох материал, шийдвэрлэлтийг цаг тухай бүрд нь Монгол Улсын ёс зүйн хорооны “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем” болох hrm.csc.gov.mn цахим системд бүртгэж ажиллаж байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдад сургалт зохион байгуулах, судалгаа авах ажлуудын бэлтгэл хангаж байна.





Ёс зүйн дэд хорооны гишүүдийн ирцийн бүртгэлийг доорх хүснэгтээр үзүүлэв.

2025 оны эхний хагас жил:

№	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн нэрс	Хурлын дугаар				
		1-р хурал 2025.05.06	2-р хурал 2025.05.30	3-р хурал 2025.06.03	4-р хурал 2025.06.12	5-р хурал 2025.06.13
1	С.Батхуяг	+	+	+	+	+
2	Л.Нямхүү	+	+	+	+	+
3	Б.Чулуунчимэг	+	+	+	+	+
4	Н.Буянтогтох	+	+	+	+	+
5	Э.Мөнхбаяр	+	+	+	+	+

2025 оны жилийн эцэс:

№	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн нэрс	Хурлын дугаар				
		6-р хурал 2025.07.06	7-р хурал 2025.09.03	8-р хурал 2025.09.15	9-р хурал 2025.10.12	10-р хурал 2025.12.08
1	С.Батхуяг	+	+			
2	Л.Нямхүү	+	+	+	+	+
3	Б.Чулуунчимэг	+	+	+	+	+
4	Н.Буянтогтох	+	+			
5	Э.Мөнхбаяр	+	+	+	+	+

БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧИГ Э.МӨНХБАЯР

ХЯНАСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ГИШҮҮН Л.НЯМХҮҮ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ГИШҮҮН Б.ЧУЛУУНЧИМЭГ